АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/015/-НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор Э.Нямсүрэн<br>Цахим хаяг: nyamsurene@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 162

танай ______-ны №______-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.БАТЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Архангай аймгийн Хотонт сумын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй 123,307.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй. Үүнд:

5. Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр малын тоо толгойн албан татварын орлого 50,754.0 мянган төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэхэд анхаарч ажиллаагүй;
6. Хоршоо хөгжүүлэх сангаас 2013- 2024 онуудад зээл авсан 2 хоршоо, 1 иргэнтэй холбоотой нийт 19,485.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй

Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайлан материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, 12 дугаар зүйлийн 12.1.16, МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Сумын засаг даргын санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан ,төсвийн гүйцэтгэл ЕБС, Хүүхдийн цэцэрлэг ,ЭМТ, соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийн нэгтгэсэн. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг , жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг ,ерөнхий боловсрол , эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 1,978,400.2 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,875,999.7 мянган төгрөгийг зарцуулж 102,400.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хотонт сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлийн Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 76.5 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| № | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 743,703.19 | 807,237.89 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 379,110.12 | 445,733.73 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 288,157.73 | 262,116.33 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 56,595.33 | 68,547.83 |
| 5 | 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | 19,840 | 30,840 |
| 6 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,582,007.92 | 3,318,779.71 |
| 7 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,582,007.92 | 3,318,779.71 |
| 8 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 2,541,997.92 | 2,976,723.71 |
| 9 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 40,010 | 342,056 |
| 10 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 3,325,711.1 | 4,126,017.6 |
| 11 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 113,437.1 |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 113,437.1 |
| 13 | 2.1.1.03 Өглөг | - | 113,437.1 |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,325,711.1 | 4,012,580.5 |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 3,325,711.1 | 4,012,580.5 |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 545,657.47 | 545,657.47 |
| 17 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 1,906,721.14 | 2,593,590.54 |
| 18 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 873,332.49 | 873,332.49 |
| 19 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 3,325,711.1 | 4,126,017.6 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */ мянган төгрөгөөр /*

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2,242,478.13 | 3,120,992 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 959,718.52 | 858,851.82 |
| 3 | Орлогын албан татвар | 695,336.76 | 644,566.54 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | 695,217.96 | 683,063.22 |
| 5 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | -38,628.67 |
| 6 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 118.8 | 132.0 |
| 7 | Хөрөнгийн албан татвар | 193,836.65 | 131,285.84 |
| 8 | Бусад татвар, төлбөр, хураамж | 70,545.11 | 82,999.43 |
| 9 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 359,237.18 | 2,262,140.18 |
| 10 | Тусламжийн орлого | - | 1,290,651.39 |
| 11 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 923,522.43 | - |
| 12 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,507,190.12 | 2,211,264.48 |
| 13 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,487,190.12 | 1,758,722.05 |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,416,978.12 | 1,739,564.65 |
| 15 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 745,338.64 | 895,674 |
| 16 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 92,276.34 | 111,348.44 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 206,052.93 | 251,809.85 |
| 18 | Хангамж, бараа материалын зардал | 92,007.84 | 67,710.29 |
| 19 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,446.12 | 62,701.39 |
| 20 | Томилолт, зочны зардал | 5,703.6 | 11,580 |
| 21 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 45,335.91 | 31,321.28 |
| 22 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,816.73 | 307,419.41 |
| 23 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 70,212 | 19,157.4 |
| 24 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,000 | 452,542.43 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 735,288.01 | 909,727.52 |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 418,639.91 | 225,130.62 |
| 27 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | -418,639.91 | -225,130.62 |
| 28 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 316,648.1 | 684,596.9 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,037,006.68 | 2,376,011.76 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 959,718.52 | 858,851.82 |
| 3 | Орлогын албан татвар | 695,336.76 | 644,566.54 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | -38,628.67 |
| 5 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 118.8 | 132 |
| 6 | Хөрөнгийн албан татвар | 193,836.65 | 131,285.84 |
| 7 | Бусад татвар, төлбөр, хураамж | 70,545.11 | 82,999.43 |
| 8 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 10,819.5 | 14,292.65 |
| 9 | Газрын төлбөр | 36,855.12 | 15,408.71 |
| 10 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 22,870.5 | 53,298.07 |
| 11 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 153,765.73 | 1,517,159.95 |
| 12 | Нийтлэг татварын бус орлого | 153,765.73 | 66,179.71 |
| 13 | Тусламжийн орлого | - | 1,290,651.39 |
| 14 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 160,328.84 |
| 15 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 923,522.43 | - |
| 16 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,354,006.33 | 1,505,715.09 |
| 17 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,354,006.33 | 1,505,715.09 |
| 18 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,281,764.33 | 1,485,624.89 |
| 19 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 741,194.45 | 895,614 |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 92,276.34 | 111,348.44 |
| 21 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 206,052.93 | 263,762.35 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 50,519.46 | 57,141.54 |
| 23 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,876.1 | 62,761.39 |
| 24 | Томилолт, зочны зардал | 5,703.6 | 11,379 |
| 25 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 60,360.94 | 30,421.13 |
| 26 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,780.5 | 53,197.05 |
| 27 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 72,242 | 20,090.2 |
| 28 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 683,000.35 | 870,296.67 |
| 29 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 485,839.91 | 803,673.06 |
| 30 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 485,839.91 | 803,673.06 |
| 31 | Дотоод эх үүсвэрээр | 485,839.91 | 803,673.06 |
| 32 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (485,839.91) | (803,673.06) |
| 33 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 70,000 | - |
| 34 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (70,000) | - |
| 35 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 127,160.43 | 66,623.61 |
| 36 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 251,949.69 | 379,110.12 |
| 37 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 379,110.12 | 445,733.73 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,052,270.2 | | 3,052,270.2 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (43,207.2) | | (43,207.2) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,009,063 | | 3,009,063 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | 316,648.1 | | 316,648.1 |
| 5 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,325,711.1 | | 3,325,711.1 |
| 6 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,325,711.1 | | 3,325,711.1 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 2,272.5 | | 2,272.5 |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,327,983.6 | | 3,327,983.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 684,596.9 | | 684,596.9 |
| 10 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,012,580.5 | | 4,012,580.5 |

## 2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / мянган төгрөгөөр /

| код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 998,716.40 | 925,031.53 |
| 11 | Татварын орлого | 766,513.50 | 858,851.8 |
| 110 | Орлогын албан татвар | 528,423.50 | 644,566.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 568,791.50 | 683,063.2 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 406,000.00 | 513,110.5 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 28,341.50 | 18,158.3 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 130,000.00 | 140,681.7 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 3,000.00 | 8,198.9 |
| 110008 | Шууд бус орлого | 1,450.00 | 2,913.9 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (40,500.00) | (38,628.7) |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (40,500.00) | (38,628.7) |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар | 132.00 | 132.0 |
| 110201 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар | 132.00 | 132.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 174,451.00 | 131,285.8 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 2,541.00 | 10,039.8 |
| 113002 | Бууны албан татвар | 2,910.00 | 3,000.0 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 169,000.00 | 118,246.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 63,639.00 | 82,999.4 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 14,064.80 | 14,292.7 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 3,796.80 | 4,015.2 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 10,268.00 | 10,277.5 |
| 1181 | Газрын төлбөр | 9,547.10 | 15,408.7 |
| 118101 | Газрын төлбөр | 9,047.10 | 9,951.6 |
| 118102 | Дуудлага худалдаа | 500.00 | 5,457.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 40,027.10 | 53,298.1 |
| 118201 | Ойн нөөц ашигласны төлбөр | 12,818.10 | 15,678.0 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 21,009.00 | 23,880.0 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 6,200.00 | 13,740.0 |
| 12 | Татварын бус орлого | 232,202.90 | 66,179.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 232,202.90 | 66,179.7 |
| 120003 | Торгуулийн орлого | 3,500.00 | 8,211.4 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 228,202.90 | 50,092.8 |
| 120009 | Бусад орлого | 500.00 | 7,875.5 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,334,209.50 | 1,875,999.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,495,882.80 | 1,394,020.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,460,281.40 | 1,373,930.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 913,368.70 | 895,614.0 |
| 210101 | Үндсэн цалин | 708,008.40 | 498,308.4 |
| 210102 | Нэмэгдэл | 154,954.70 | 320,304.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,248.90 | 20,595.4 |
| 210104 | Урамшуулал | 5,156.70 | 26,986.6 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 30,000.00 | 29,418.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 112,622.6 | 111,348.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,104.30 | 75,454.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,129.60 | 8,979.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,564.80 | 4,489.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,564.80 | 4,489,696.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,259.10 | 17,935.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 286,382.80 | 263,762.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 102,995.10 | 91,076.5 |
| .,I…. | Түлш, халаалт | 171,857.70 | 161,513.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,530.00 | 11,172.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69,564.90 | 55,246.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 18,507.70 | 14,504.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,600.00 | 26,609.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,800.00 | 5,529.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 916.00 | 228.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,241.20 | 8,240.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500.00 | 134.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 75,173.00 | 68,261.4 |
| 210602 | Тавилга | 3,000.00 | 3,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 72,173.00 | 65,261.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,960.00 | 11,379.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,960.00 | 11,379.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 45,132.00 | 26,470.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,102.00 | 25,694.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 690.00 | 0.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800.00 | 99.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 40.00 | 22.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,500.00 | 654.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,700.00 | 53,197.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,000.00 | 48,958.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,700.00 | 4,238.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,601.40 | 20,090.2 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 13,500.00 | 8,989.2 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 13,500.00 | 8,989.2 |
| 213103 | Төсвийн санхүүжилт | - | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 22,101.40 | 11,101.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,101.40 | 11,101.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 508,293.90 | 370,630.6 |
| 221001 | Их засвар | 25,000.00 | 25,000.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 31,000.00 | 30,029.8 |
| 223001 | Бусад хөрөнгө | 452,293.90 | 315,600.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 217,410.20 | 0.0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 217,410.20 | 0.0 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 720,365.70 | (839,619.7) |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (720,365.70) | 839,619.7 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (720,365.70) | 839,619.7 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 379,110.1 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 445,733.7 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 57 | 57 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 28 | 28 |
| 620001 | Удирдах ажилтан | 11 | 11 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1 | 1 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 28 | 28 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11 | 11 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7 | 7 |
| 650010 | Гэрээт ажилтан | 1 | 1 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 9 | 9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/мянган төгрөгөөр /

| код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 433,388.49 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 433,388.49 |
| 122 | Тусламжийн орлого | 433,388.49 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 433,388.49 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 433,388.49 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 433,388.49 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 433,388.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,846.06 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,846.06 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,895.44 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,715.44 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 180.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,950.62 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,950.62 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 427,542.43 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 427,542.43 |
| 220001 | Барилга байгууламж | 427,542.43 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 104,700.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл буюу дутуу олгосон 104,700.0 мянган төгрөгийг өр төлбөрөөр санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй нийт 70,239.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүллээ.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 70,239.4 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын зөрчил нь нь сумын засаг даргын санхүүгийн албаны өдөр тутмын хяналт муутай холбоотой бөгөөд зөрчлийн нөлөөллийг үнэлж  нийт 53,067.6 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг гэж үнэлснээр нийт материаллаг зөрчлийн дүн 123,307.0 мянган төгрөг болсон.

Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 35,013.1 мянган төгрөгөөс их байгаа тул “**Хязгаарлалттай”**дүгнэлт өглөө.

**3.1 Албан шаардлага**

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр малын тоо толгойн албан татварын орлого 50,754.0 мянган төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд хангаж биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

3.1.2 Хоршоо хөгжүүлэх сангаас 2013- 2024 онуудад зээл авсан 2 хоршоо, 1 иргэнтэй холбоотой нийт 19,485,414  төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх талаар бодитой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна

Энэ нь Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мян.төг/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг орхигдуулсан | | Үнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хотонт сумын Засаг дарга | 1 | 104,700.0 | 1 | 104,700.0 | 1 | 104,700.0 |
| **Дүн** | **1** | **104,700.0** | **1** | **104,700.0** | **1** | **104,700.0** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мян.төг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| МТТАТ-н орлого  50,754.0 мянган төгрөгөөр тасарсан байна. | 1 | 50,754.00 | | | 1 | 50,754.00 |
| ХХСангаас хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх талаар бодитой үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй | 1 | 19,485.40 | | | 1 | 19,485.40 |
| **Нийт дүн** | **2** | 70,239.40 | | | **2** | 70,239.40 |

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мян.төг/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг даргын тамгын газар | 2 | 53,067.60 | | | 2 | 53,067.60 |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | - | - | | | - | - |
| Хоршоо хөгжүүлэх сан | 2 | 39,345.70 | | | 2 | 39,345.70 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 3 | 35,427.00 | | | 3 | 35,427.00 |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч | 1 | 50,754.00 | | | 1 | 50,754.00 |
| **Дүн** | **8** | **178,594.30** | | | **8** | **178,594.30** |